

15.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ХҮН АМЫН ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 8 дугаар
сарын 26-ний өдөр

№ А81/А89 286

Улаанбаатар хот

Цаг уурын хүнд нөхцөлтэй
орны жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Дипломат албаны тухай хуулийн 22 дугаар заалтыг
үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол хүний хувьд ажиллаж, амьдрахад цаг уурын хүнд нөхцөлтэй гадаад орны жагсаалтад Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улс, Бүгд Найрамдах Куба Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Тайландын Вант Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Кувейт Улс, Бүгд Найрамдах Индонез Улс болон Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсыг оруулан баталсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Цаг уурын хүнд нөхцөлтэй орны жагсаалтыг батлах тухай” 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 19/69/100 дугаартай Гадаад хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

